



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 19 өдөр

Дугаар А/520

Булган сум

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” XIX/08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. “Алтаргана 2024” XV наадмын урилга, хөтөлбөрийн эх бэлтгэл, хэвлэлийн ажлын гүйцэтгэгчээр Ерөнхий дизайнер Б.Хонгорзултай 2,835,000 (хоёр сая найман зуун гучин таван мянга) төгрөгөөр гэрээ байгуулж, гэрээнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (М.Батчимэг)-д үүрэг болгосугай.

2. Гэрээнд заасан ажлыг холбогдох стандарт, журам, зааврын дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг Ерөнхий дизайнер (Б.Хонгорзул)-д даалгасугай.

3. Дээрх ажлын гүйцэтгэлийг санхүүжилт 2,835,000 (хоёр сая найман зуун гучин таван мянга) төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн “Алтаргана 2024” арга хэмжээний төлөвлөгдсөн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6324010893

07 Аймгийн Засаг даргын 2024 оны
дүгээр сарын 19 ны өдрийн А/Б.Д. дугаар
захирамжийн хавсралт



“Алтаргана 2024” олон улсын XV их наадмын урилга, хөтөлбөрийн эх, хэвлэлийн зардлын тооцоо

Д/д	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	1	2	3	4
2	Урилгын эх бэлтгэл /A5, 8 нүүр/	1	70,000	70,000
3	Хөтөлбөр эх бэлтгэл /A4, 6 нүүр/	1	140,000	140,000
4	Хөтөлбөр хэвлэл	250ш	3,000	750,000
5	Урилга хэвлэл	250ш	7,500	1,875,000
Нийт үнэ			2,835,000	